

**“ЭРДЭНЭТ СУВАРГА” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 02 дугаар сарын 23

Дугаар № 01

Булган хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 02-р сарын 23-ны өдөр 10.00 цагт Булган хот, Булган сум, 1 баг, зам ангийн хурлын танхимд хуралдав.

Хуралд оролцсон хүмүүс:

ТУЗ-ын дарга: О.Маралмаа

ТУЗ-ын гишүүн: Ж.Жадамба

ТУЗ-ын гишүүн : Л.Цангилагбар

ТУЗ-ын хараат бус гишүүн: З.Дэлгэрмаа

Хувьцаа эзэмшигч:

1. Н. Одонбилэг

133,531 ширхэг хувьцааны

саналын эрхтэйгээр оролцов.

Хурлын тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан 156,054 хувьцаанаас саналын эрхтэй хувьцааны тоог 133,531 ширхэг хувьцаагаар тогтоож, хурлын ирц 85,57 хувьтай байгааг мэдээлж, компанийн тухай хуулийн 69.1 заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлж болохийг хурлын даргад зөвшөөрөв.

Хурал 10 цаг 00 минутанд эхлэв.

Хурлын дарга Л. Гантуяа хурлыг нээж, хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлуудийг танилцуулав.

Хурлын дэг:

1. Хурлын ирцийг бүртгэх. / Тоологын комисс/ 09.30-10.00 цаг
2. Хурлын ирцийг мэдээлэх. / Тоологын комисс/ 10.00 цаг
3. Хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах.
/ Хурлын дарга /
4. Хурлаар хэлэлцэх асуудалыг дараалалын дагуу уншиж танилцуулах. Үүнд: а/
 - ✓ Компанийн санхүүгийн тайлангийн түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлтийг хэлэлцэх
 - ✓ Компанийн 2019 оны бизнес үйл ажиллагааны тайлан
 - ✓ Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөө



- ✓ Ноогдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн, батлах

б/ Компанийн шинэчлэн найруулсан дүрэм

в/ ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг танилцуулах

5. Асуулт хариулт, санал шүүмжлэл тавих. / нэг хүн үг хэлэх хугацаа 10 минут /
6. Хурлын завсарлага.
7. Санал хураалтын дүнг хуралд оролцогчдод танилцуулах. / Тоологын комисс /
8. Хурлаас гаргах шийдвэр, тогтоолыг танилцуулах. / Хурлын дарга /
9. Хурлыг хаах. / Хурлын дарга /

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

Компанийн ТУЗ-ийн 2020 оны 02-р сарын 12-ны өдрийн 01/20 тоот тогтоолын дагуу тус ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. Компанийн санхүүгийн тайлангийн түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах.
3. Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн, батлах.
4. Ноогдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэн батлах.
5. Компанийн шинэчлэн найруулсан дүрмийн төслийг хэлэлцэх.
6. ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодыг сонгох.

Гүйцэтгэх захирал Н.Одонбилэг: Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон 2020 оны бизнес төлөвлөгөөний талаар уншиж, танилцуулав. /Тайлан хурлын материалд /

Н. Баярмаа: Компанийн 2019 оны санхүүгийн тайлангийн талаар танилцуулав.

Хурлын дарга Л. Гантуяа хурлаар хэлэлцэх асуудлуудыг дэс дарааллын дагуу уншиж, танилцуулав.

Асуулт, хариулт :

З.Дэлгэрмаа: - Компани сүүлийн хэдэн жил ноогдол ашиг өгч чадахгүй байгаад тайлбар өгөх үү.

Н. Баярмаа: - Санхүүгийн талаас нь би тайлбар өгөхөд манай компани нь сүүлийн жил хурал хуралдаагүй бөгөөд 2019 онд ажил хийгээгүй 2018 онд хийсэн ажлын үлдэгдэл төлбөр орж ирсэн нь компанийн үйл ажиллагааны зардалд зарцуулагдсан.

З.Дэлгэрмаа: - Компанийн тоног төхөөрөмжөд шинэчлэл хийгдсэн үү.

Н.Одонбилэг: - Урд жилүүдэд бид дорвитой ажил хийж чадаагүй. 2020 онд улс болон нийслэлийн чанартай авто замуудын тендерт идэвхтэй оролцон борлуулалтын орлого болон ашгийн хэмжээг нэмэгдүүлсэнээр компанийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийхээр төлөвлөсөн байна.

З.Дэлгэрмаа: - Хувьцааны зах зээлийн үнэ хэдэн төгрөг вэ.

Л. Гантуяа: - Нэгж хувьцааны арилжааны ханш 7670 /Долоон мянга зургаан зуун далан/ төгрөг байна.

Л. Гантуяа: - Хувьцаа эзэмшигчидээ өөр асуух зүйл байна уу. Байхгүй бол саналаа өгөөд түр завсарлана уу.

Асуулт хариултын цаг дуусч тоологын комисст саналын хуудасаа өгөөд хувьцаа эзэмшигчид түр завсарлав.

Тооллогын комисс саналын хуудасны дүнг нэгтгэн танилцуулав.

Л.Гантуяа: - Нийт 156,054 ширхэг хувьцааны саналын эрхтэй 7 хувьцаа эзэмшигч хуралд оролцохоос биечлэн ирсэн 1 хувьцаа эзэмшигч саналаа өгч, нийт дүнгээр 1 хувьцаа эзэмшигчийн саналыг нэгтгэллээ.

Үүнд:

Санхүүгийн тайлан	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
Үйл ажиллагааны тайлан	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
Бизнес төлөвлөгөө	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
Ногдол ашиг хувиарлахгүй тухай	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
Компанийн шинэчлэсэн дүрэм	зөвшөөрсөн 85,57 хувь,	татгалзсан 0 хувь
ХХК дүрмийн төсөл	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь
ТУЗ-д нэр дэвшүүлэх тухай	зөвшөөрсөн 85,57 хувь ,	татгалзсан 0 хувь

- Ердийн нэр дэвшигч дэвшүүлэх
- Хараат бус гишүүд дэвшүүлэх

Хурлын дарга Л. Гантуяа ХЭЭХурлаас гарсан ХЭЭХ-ийн тогтоолуудын уншиж, танилцууллаа.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн санхүүгийн тайлангийн түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт болон холбогдох тайлангуудыг холбогдох цахим хуудсанд тогтмол байршуулж байлгах, цаашид компанийн үйл ажиллагааг сайжруулах боломжит бүх арга хэмжээг авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Н.Одонбилэг/-т даалгасугай.
3. Компани нь 2019 онд үндсэн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбогдуулан ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
4. “Эрдэнэт суварга” ХК-ийн дүрмийг 01 дүгээр хавсралтаар баталсугай.
5. Компанийн ТУЗ болон хараат бус гишүүдийн дараах бүрэлдхүүнтэйгээр сонгосугай:

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд:

1. О. Маралмаа
2. Н. Одонбилэг
3. Ж.Жадамба
4. Н.Баярмаа
5. Х.Гончигсүрэн
6. Л.Цангилагбар

ТУЗ-ын хараат бус гишүүдэд:

1. Л.Гантуяа
2. З.Дэлгэрмаа
3. Ц.Сайнжаргал

ТУЗ-ын даргаар О.Маралмаа-г сонгов.

Хурлын дарга хурлыг хааж, үг хэлсэнээр Хурал 12.00 цагт өндөрлөв

Хурал удирдсан:
Хурлын дарга



/Л.Гантуяа/